**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН**
**2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

**НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.1.<br>Навигацын хиймэл дагуулаас мэдээ хүлээн авах суурин станцыг өргөжүүлэх замаар байрлалын сүлжээний нарийвчлалыг 2 см хүртэл сайжруулж, геодезийн хэмжил зураглалын үйл ажиллагаанд ашиглана.** | | | | | | | |
| **1.2.1** | **GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын үйл ажиллагаа** | **Үйл ажиллагаа** | **1.Байнгын ажиллагаатай станц-43<br>2.Бодит агшны хяналтын хэмжилт - 4** | **2013-2017 онд Улсын төсвөөр 38, УБ хотын төсвөөр 5 станц суурилуулсан.<br>2019 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай 43 станцын нэгдсэн удирдлагын тогтолцоо бүрдүүлсэн.** | **43 Байнгын ажиллагаатай станцыг нэгдсэн сүлжээнд холбогдож, солбицол, өндрийн нэгдсэн тогтолцоонд алдаагүй зөв хэмжилт хийх боломж бүрдсэн байна.** | | |
| 1.2.1.1 | GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын хэвийн үйл ажиллагааг хангах | Үйл ажиллагаа | Байнгын ажиллагаатай станцын тоо | 2013-2017 онд Улсын төсвөөр 38, нийслэлийн төсвөөр УБ хотод 5 станц суурилуулсан.<br>2019 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай 43 станцын нэгдсэн удирдлагын тогтолцоо | GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын тасралтгүй хэвийн ажиллагааг хангаж ажилласан байна. | Аймгийн төвийн GOA1 байнгын ажиллагаатай суурин станцын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллаж байна. 2024 онд 1 хоног буюу 24 цаг доголдсон. Байнгын ажиллагаатай суурин станцын шугам сүлжээ доголдоогүй болно. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | бүрдүүлсэн. | | | |
| 1.2.1.2 | Аймгийн төвийн GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцыг бодит агшны хэмжилтээр хяналт тавих | Үйл ажиллагаа | Бодит агшны хяналтын хэмжилт - 4 | 2020 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын удирдлагын програм хангамжийг шинэчилж, хэрэглээнд нэвтрүүлсэн. | Аймгийн төвд суурилуулсан станцын бодит агшны нарийвчлалыг улиралд 1 удаагийн шалгалтын хэмжилт, сум суурин газрын станцуудад хагас жилд 1 удаагийн шалгалтын хэмжилт хийж, үр дүнг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Аймгийн төвийн станцын бодит агшны 1 дүгээр улирлын хэмжилтийг 2024 оны 01 сарын 18-ны өдрийн 161 албан тоотоор, 2 дугаар улирлын хэмжилтийг 2024 оны 05 сарын 30-ны өдөр, 3 дугаар улирлын хэмжилтийг 2024 оны 08 сарын 08-ны өдөр, 4 дүгээр улирлын хэмжилтийг 2024 оны 11 сарын 01-ны өөр тус тус хийж гүйцэтгэн \\192.168.20.24\Geodesy\GNSS хяналт хэмжилт 2024\I, II, III, IV улирал\govi-altai дотор байршуулан ажилласан. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.7.<br>Зайнаас тандан судлалын технологид суурилсан газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг хөгжүүлж, нэвтрүүлнэ.** | | | | | | | |
| **1.7.1** | **Газар ашиглалт болон газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн сүлжээний мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх** | **Улсын төсөв** | **Мониторингийн 350 цэг** | **2021 онд мониторингийн сүлжээгээр байгуулсан 500 цэгт газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажил хийгдсэн.** | **Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн сүлжээний 1100 цэгээс мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийж, бусад байгууллагууд ашиглах нөхцөл боломжоор хангагдсан байна.** | | |
| 1.7.1.2 | Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэх шаардлагатай газрын байршил, хугацаа, хуваарийн талаарх судалгааг аймгийн хэмжээнд | Үйл ажиллагаа | 1 судалгаа | - | **Эхний хагас жилд:** Сум болон холбогдох байгууллагаас газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийгдсэн газрын байршил, | Аймгийн хэмжээнд газар өмчлөлийн 7500 нэгж талбар, эзэмшлийн 11500 нэгж талбар, ашиглалтын 6 нэгж талбар нийт 19006 нэгж талбар 8891.8 га газарт Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлд заасан захиалгат хянан баталгаа хийлгэх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гаргаж ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх | | | | хугацааны талаарх судалгааг авч нэгтгэнэ. Тус судалгаанд дүн шинжилгээ хийж газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэх шаардлагатай газрын байршил, хугацаа, хуваарийн талаарх судалгааг аймгийн хэмжээнд гаргаж ГЗБГЗЗЕГ-т хүргүүлнэ. | шаардлагатай байна. Судалгааг аймгийн хэмжээнд нэгтгэн гаргасан, нэгж талбар газрыг өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдад мэдэгдэл хүргүүлэх, газар эзэмших гэрээ дүгнэх ажлыг зохион байгуулсан. | |
| **1.7.2** | **Газар хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг зохион байгуулах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих** | **Орон нутгийн төсөв** | **Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний тоо** | **Хүчтэй элэгдэл, эвдрэлд орсон тариалан болон атаршсан газарт нөхөн сэргээлт хийх төлөвлөгөө батлагдсан. Газрын мониторингийн системийг хэрэглээнд нэвтрүүлснээр газар хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хянах боломж бүрдсэн.** | **Хүчтэй элэгдэл, эвдрэлд орсон тариалан болон атаршсан газарт нөхөн сэргээлт хийх төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломж бүрдсэн байна.** | | |
| 1.7.2.1 | Аймгийн хэмжээнд хохирол учирсан, доройтолд өртсөн газруудын байршлыг гаргаж, нөхөн сэргээх байршил, талбайн | Үйл ажиллагаа | 1 төлөвлөгөө | - | **Эхний хагас жилд:** Газрын нэгдмэл сангийн ангилал тус бүрээр хохирол учирсан, доройтолд өртсөн талбайн | Гар аргаар ашигт малтмал олборололтын улмаас эвдэрсэн 11 сумын 133.45 га, түгээмэл тархацтай ашигт малтмалын улмаас эвдэрсэн 3 сумын 26.69 га, уул уурхайн ашигт малтмал | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах | | | | байршлыг тодорхойлж, нөхөн сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн хэмжээнд боловсруулж, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.<br>**Жилийн эцэст:**<br>Нөхөн сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөөг сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна. | олборлолтын үйл ажиллагаанд өртөж орхигдсон 8 сумын 297.32 га нийт 18 сумын 457.46 га газрын байршлыг 18 сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, газрын даамал хамтран тодорхойлон зурагжуулсан.<br>Хууль бусаар ашигт малтмал олборлолтын үйл ажиллагааны улмаас Тайшир, Есөнбулаг сумын нутаг дэвсгэрт эвдрэлд орж орхигдсон 13.8 га талбайг ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй “Хан Алтай ресурс”, “Болд гянт болд” ХХК-ууд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд, орон нутгийн төсөв болон байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 8.41 га талбайг, нийгмийн хариуцлагын хүрээнд төрийн бус байгууллагуудаар 7.98 га талбайг нийт 30.19 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг орон нутгийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар стандартын дагуу хийлгэн хүлээн авч 154.0 сая төгрөгийг зарцуулан ажиллалаа. Ажлын үр дүн ГНС-ын тайланд тусган ажиллаж байна. | |
| 1.7.2.2 | Аймгийн хэмжээнд хийгдсэн хот, тосгон, бусад суурин газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажил болон төлөвлөгөөт хянан | Үйл ажиллаг аа | Цахим системд оруулсан тоон мэдээлэл | - | **Эхний хагас жилд:**<br>Газрын мониторингийн цахим системд ороогүй 2010-2023 оны хооронд хийгдсэн хот, тосгон, бусад суурин газрын | Газрын мониторингийн цахим системд ороогүй 45 нэгж талбарын захиалгат хянан баталгааны судалгааг гаргаж, тоон мэдээллийг нэгтгэн нөхөн бүрдүүлэх ажлыг зохион байгуулж байна.<br>Мөн Есөнбулаг сумын орон нутгийн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | баталгааны ажлуудын тайлан, тоон мэдээллийг нэгтгэж, Газрын мониторингийн цахим системд оруулах | | | | төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны тайлан, тоон мэдээллийг стандартын дагуу нэгтэж мэдээллийн санг бий болгосон байна.<br>**Жилийн эцэст:**<br>Мэдээллийн санг Газрын мониторингийн цахим системд оруулсан байна. | төсвийн 28 сая төгрөгөөр “Есөнбулаг сумын хот суурин газрын хянан баталгааны ажил”-ыг гүйцэтгүүлэх тендэрийг аймгийн худалдан авах ажиллагааны газраар дамжуулан зарлаж, гүйцэтгэгчээр Лапланд эко ХХК шалгарсан. 2024 оны 10 сард ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. 2024 оны 12 сарын 15-ны өдрийн дотор хүлээлгэн өгөх гэрээний дагуу гүйцэтгэгч ажиллаж байна. Ингэснээр Бугат, Дарив, Эрдэнэ, Есөнбулаг сумд хот суурин газрын төлөв байдлын төлөвлөгөөт хянан баталгааг хуулийн хугацаанд хүчин төгөлдөр мөрдөж байна.<br>Энэ онд захиалгат хянан баталгааны 458 ширхэг мэдэгдэх хуудсыг үүсгэж газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчид хүргүүлснээс 110 нэгж талбарт хянан баталгааны дүгнэлт ирж баталгаажсан байна.<br>Уул уурхайн ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй талбайд газар эзэмшиж Хан-Алтай ХХК-ний 55 нэгж талбар 1275 га талбайд газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны мэдэгдлийг үүсгэж, мэргжлийн тусгай зөвшөөрөлтөй Тод байгаль ХХК-иар гүйцэтгүүлэн газрын мониторингийн цахим системд бүртгэн улс, аймгийн байнгын шинжээч баталгаажуулсан байна. | |
| 1.7.2.3 | Газар хамгаалах, нөхөн сэргээх зардлын зах зээлийн үнийн судалгаа | Үйл ажиллагаа | Судалгаа-1 | - | **Эхний хагас жилд:**<br>Газрын нөхөн сэргээлтийн ажлын үе | Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газартай хамтран нөхөн сэргээх зардлын зах зээлийн | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хийх | | | | шатыг нарийвчлан тодорхойлж, нөхөн сэргээлт хийгдэхэд шаардагдсан зардлын мэдээллийг цуглуулж, задаргааг тооцсон судалгааг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | үнийн судалгааг гарган, 2008-2024 оны ажлуудад дүгнэлт хийж үзэхэд техникийн нөхөн сэргээлт гар аргаар ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааны улмаас эвдэрч орхигдсон талбайд 1 га талбайд дунджаар 5-6 сая төгрөгөөр, уул уурхайн 1 га талбайн нөхөн сэргээлтийг дунджаар 32-35 сая төгрөгөөр гүйцэтгэсэн байна. | |
| **1.7.3** | **Мониторингийн системд зайнаас тандан судлалын арга, технологийг нэвтрүүлэх** | **Урсгал төсөв** | **Суурь зургууд гарсан байна.** | **2020 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс Газрын мониторингийн системийг хэрэглээнд нэвтрүүлсэн.** | **Мониторингийн системд зайнаас тандан судлалын арга, технологийг ашиглах нэмэлт хөгжүүлэлт хийсэн байна.** | | |
| 1.7.3.1 | Газрын мониторингийн үйл ажиллагаанд зайнаас тандан судлалын арга, технологийг ашиглан, газрын бүрхэвчийн өөрчлөлт, доройтол, элэгдэл, эвдрэл, бэлчээрийн газрын даац, чадавхыг тодорхойлох | Үйл ажиллагаа | Ирүүлсэн тайлангийн тоо | БХБС-ын 2022 оны 126 дугаар тушаалаар “Зайнаас тандан судлалын аргаар бэлчээрийн газрын мониторинг хийх аргачилсан заавар” батлагдсан. | **Жилийн эцэст:** Газрын даамал, мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйгээр хангаж, хиймэл дагуулын 6-9 дүгээр сарын мэдээнд үндэслэн сум тус бүрээр ургамлын бүрхэвчийн зураглалыг хийж, бэлчээрийн газрын биомасс, даацыг тооцон аймгийн хэмжээнд элэгдэл, эвдрэл, доройтолд өртсөн газрыг тодорхойлж, үр дүнг ГЗБГЗЗЕГ-т | Зайнаас тандан судлалын арга технологийг ашиглан газрын бүрхэвчийн өөрчлөлт, доройтол, элэгдэл эвдрэл, бэлчээрийн газрын даац, чадавхийг тодорхойлох арга зүйг эзэмшүүлэх сургалтыг цахимаар 18 сумын газрын даамлуудад 2024 оны 4 сард зохион байгуулсан.<br>Зайнаас тандан судалгаа, бэлчээрийн газрын фото мониторингийн судалгааны үр дүнд тулгуурлан бэлчээрийн даацыг тооцон гаргасан. Боломжит даац нь аймгийн дүнгээр 10540554.7 байгаа бөгөөд хонин толгойд шилжүүлснээр 234389 болж бэлчээрийн даац 1704.519 хонин толгойгоор хэтрээгүй үзүүлэлттэй | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүргүүлсэн байна. | байна. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.8.**<br>**Газар, байгаль, эдийн засаг, нийгмийн нөөц, чадавхад тулгуурлан газар ашиглалт, хамгаалалтын үр ашгийг дээшлүүлэх, газрыг иргэд болон эдийн засгийн хувьд үндэслэл сайтай, үр ашигтай, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан газар зохион байгуулалтыг хөгжүүлж, газрын нөөцүүдийг оновчтой ашиглаж хэвшинэ.** | | | | | | | |
| **1.8.1** | **Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Улсын хэмжээний тайлан** | **2018 онд Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулсан.** | **Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, явцыг жил бүр Засгийн газарт танилцуулсан байна.** | | |
| 1.8.1.1 | Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтийг гаргаж ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх | Үйл ажиллагаа | Хэрэгжилтийн тайлан-1 | Засгийн газрын 2018 оны 384-р тогтоолоор Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлагдсан. | **Эхний хагас жилд:** Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтийг 1-р улиралд багтаан гаргаж, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Аймгийн Засаг даргын 2020 оны 01 сарын 21-ны өдрийн А/16 дугаар захирамжаар Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөл, арга хэмжээг аймгийн хэмжээнд авч хэрэгжүүлэх, үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнөөс аймгийн хэмжээнд хамаарах 11 бүлэг 68 зүйл арга хэмжээний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулсан. Ажлын хэсгийн хурлыг 2023 оны 01 сарын 06-ны өдөр зохион байгуулж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, аймгийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний эхлэлийн шатны тайланг тус бүр хэлэлцсэн.<br>Мөн тус газрын 2023 оны 12 сарын 01-ны өдрийн 747 дугаар албан бичгээр ажлын хэсэгт орсон байгууллагууд руу улсын газар зохион байгуулалтын 2023 хэрэгжилтийг гарган ирүүлэхийг мэдэгдсэн. 2023 оны хэрэгжилтийг аймгийн хэмжээнд нэгтгэн гаргаж ГЗБГЗЗЕГ-т 2024 оны 01 сарын 15-ны өдрийн 33 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | |
| **1.8.2** | **Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах** | **Орон нутгийн төсөв** | **7 аймгийн болон нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө** | **12 аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан.** | **Нийслэл, Булган, Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Архангай, Баянхонгор, Ховд, Говь-Алтай аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилласан байна.** | | |
| 1.8.2.1 | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх болон тодотгон боловсруулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Дүгнэлтийн тоо | 18 аймгийн ГЗБЕТ (Говьсүмбэр, Увс, Завхан, Хөвсгөл, Өмнөговь, Дундговь, Төв, Дархан-Уул, Дорноговь, Баян-Өлгий, Булган, Баянхонгор, Орхон, Архангай, | **Эхний хагас жилд:**<br>Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах үе шатуудад хяналт тавьж, үе шатны тайлангуудад дүгнэлт гарган гүйцэтгэгчид болон ГЗБГЗЗЕГ-т | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэгчээр мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэй “Геоботаник” ХХК нь 626.7 сая төгрөгөөр гүйцэтгэх үнийн саналыг ирүүлэн шалгарсан. Ажил гүйцэтгэх гэрээг 2022 оны 07 сараас 2024 оны 04 сар хүртэлх хугацаанд байгуулсан.<br>Гүйцэтгэгчийн ирүүлсэн ажил | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Сэлэнгэ) боловсруулсан. | хүргүүлсэн байна.<br>**Жилийн эцэст:** Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд бүрэн, зөв зурагласан эсэхэд хяналт тавьсан байна. ГЗБГЗЗЕГ-аас гаргасан мэргэжлийн дүгнэлтийг үндэслэн засвар, өөрчлөлтийг гүйцэтгэгчээр хийлгэж, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, батлуулах ажлыг зохион байгуулсан байна. | гүйцэтгэх графикийн дагуу Говь-Алтай аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын үе шатны ажлууд хийгдэж аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 2 дугаар улирлын хурлаар хэлэлцүүлэн аймгийн ИТХ-ын 2024 оны 04 сарын 25-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор батлуулан хүлээлгэн өгсөн. Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газрын Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн техникийн зөвлөлийн 2024 оны 2024/05 дугаар дүгнэлт гарсан. Дүгнэлтэд заасан арга хэмжээнүүдийг Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд засварлуулан ажилласан. | |
| **1.8.3** | **Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд хяналт тавих** | **Үйл ажиллагаа** | **8 аймгийн болон нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө** | **12 аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан.** | **Шинэчлэн боловсруулсан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, үр дүнг холбогдох аймгуудад хүргүүлсэн байна.** | | |
| 1.8.3.2 | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн | Үйл ажиллагаа | Судалгаа, мэдээллийн тоо | 18 аймгийн ГЗБЕТ (Говьсүмбэр, Увс, Завхан, Хөвсгөл, Өмнөговь, | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн | Аймгийн хэмжээнд Цогт, Чандмань, Эрдэнэ сум нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөөтэй холбоотой мэдээ, судалгааг холбогдох байгууллагад хүргүүлэх | | | Дундговь, Төв, Дархан-Уул, Дорноговь, Баян-Өлгий, Булган, Баянхонгор, Орхон, Архангай, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Сэлэнгэ) боловсруулсан. 175 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулагдсан. | хөгжлийн төлөвлөгөөтэй холбоотой мэдээлэл, судалгааг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | хэрэгжүүлж байна. 2020-2023 оны хэрэгжилтийг гарган Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд оруулсан. Аймгийн Засаг даргын Тамгын газартай Вектор мэп ХХК нь “Алтай, Баян-Уул, Бигэр, Бугат, Дарив, Дэлгэр, Жаргалан, Есөнбулаг, Тайшир, Тонхил, Төгрөг, Халиун, Хөхморьт, Цээл, Шарга сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах” зөвлөх үйлчилгээний №ГААХААГ/20240103082 дугаартай гэрээг 2024 оны 04 сард байгуулан аймаг, сумын төсвөөс санхүүжүүлэн ажиллаж байна. 2024 оны 12 сард 3 сумын төлөвлөгөөг, 2025 оны 03 сард 12 сумын төлөвлөгөөг сумдад хүлээлгэн өгнө. Дээрх цахим системд төлөвлөгөөний төслийг гүйцэтгэгч нэгж талбар бүрээр ажлын даалгаварт заасны дагуу оруулж байна. Мэдээ, судалгааг тогтмол ГЗБГЗЗЕГ-т хүргүүлж байна. | |
| **1.8.4** | **Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах** | **Орон нутгийн төсөв** | **16 сум** | **98 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж, баталгаажуулсан.** | **Жил бүр 18 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.** | | |
| 1.8.4.1 | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, | Үйл ажиллагаа | Хэрэгжсэн арга хэмжээний тоо | Улсын хэмжээнд 175 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн | **Эхний хагас жилд:** Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний | Аймгийн хэмжээнд Цогт, Чандмань, Эрдэнэ сум нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тайлагнах. | | | төлөвлөгөө батлагдсан. | хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хэрэгжих ажлуудыг зохион байгуулж ажилласан байна.<br>**Жилийн эцэст:**<br>Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хэрэгжих ажлуудыг зохион байгуулж, цахим системд байршуулсан байна.<br>Хэрэгжилтийг 2024 оны 12 дугаар сард багтаан тайлагнасан байна. | хэрэгжүүлж байна. Унаган байгалын хүлцэл тогтворжилтыг хангах нь төслийн 3.2 сая төгрөгийн дэмжлэгээр Цогт, Чандмань, Эрдэнэ сумд холбогдох албан хаагчид томилолтоор ажиллаж 2020-2024 оны хэрэгжилтийг үнэлэн гаргасан. 2020-2023 оны хэрэгжилтийг гарган ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. 2024 оны 16 арга хэмжээний хэрэгжилтийг газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд бүртгэсэн. Ингэснээр төлөвлөсөн 3337 арга хэмжээнээс Цогт сум 20, Чандмана сум 24, Эрдэнэ сумын 230 нийт 274 арга хэмжээний биелэлтийг тооцон оруулсан.<br>Томилолтын ажлын үр дүнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 2020, 2021, 2022, 2023, 2024 оны хэрэгжээгүй үйл ажиллагааг 2024-2025 онд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, сумын газар зохион байгуулалтын 2025 оны төлөвлөгөө, бусад төлөвлөгөө хөтөлбөрүүдэд тусган хэрэгжилтийг зохион байгуулах чиглэлийг тус газрын 2024 оны 06 сарын 25-ны өдрийн 335 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | |
| 1.8.4.2 | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинээр боловсруулах, тодотгох талаар аймаг, орон нутгийн удирдлагуудыг мэдээ, | Үйл ажилллагаа | Санхүүжилтын хэмжээ | - | **Эхний хагас жилд:**<br>Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинээр боловсруулах болон тодотгоход | Аймгийн ИТХ-ийн 2023 оны 12 сарын 01-ны өдрийн хуралдаанаар аймгийн 2024 оны орон нутгийн төсөвт Алтай, Баян-Уул, Бигэр, Бугат, Дарив, Дэлгэр, Жаргалан, Есөнбулаг, Тайшир, Тонхил, Төгрөг, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | танилцуулгаар хангаж төлөвлөгөөний зардлыг төсөвт суулгах ажлыг зохион байгуулах | | | | шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт суулгуулах талаарх санал болон танилцуулгыг холбогдох албан тушаалтанд танилцуулах ажлыг зохион байгуулсан байна.<br>**Жилийн эцэст:**<br>Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинээр боловсруулах болон тодотгоход шаардагдах зардлыг 2025 оны төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулж, батлуулсан байна. | Халиун, Хөхморьт, Цээл, Шарга зэрэг 15 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах зардалд 600 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн. Гүйцэтгэгчээр Вектор мэп ХХК нь 567 сая төгрөгийн үнийн саналыг ирүүлэн шалгарсан. Ажил гүйцэтгэх гэрээг 2024 оны 04 сарын 04-ны өдөр байгуулсан. Мөн Чандмань сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө (2020-2027 он)-г тодотгох ажлын гүйцэтгэгчээр Вектор мэп ХХК шалгарч ажил гүйцэтгэх гэрээг 2024 оны 06 сарын 14-ны өдөр байгуулсан.<br>Гүйцэтгэгч 2024 оны 04-05 дугаар саруудад бэлтгэл үе шатны ажлыг хийж, 2024 оны 06 сарын 10-ны өдрөөс хээрийн судалгааны ажилдаа 3 чиглэлд гарч ажилласан. 2024 оны 09 сард багийн ИНХ-д төлөвлөгөөний төслийг танилцуулан санал авсан. Захиалагчийн хяналтыг үе шатны ажлуудад гүйцэтгэж байна. Вектор мэп ХХК нь 2024 оны 12 сард 3 сумын (Бигэр, Дарив, Есөнбулаг) төлөвлөгөөг, 2025 оны 03 сард 12 сумын төлөвлөгөөг сумдад хүлээлгэн өгнө. Ингэснээр Говь-Алтай аймгийн бүх сумд газар зохион байгуулалтын дунд хугацааны бодлогын баримт бичигтэй болно. | |
| 1.8.4.3 | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө | Үйл ажиллаг | Дүгнэлтийн тоо | Улсын хэмжээнд 175 сумын нутаг | **Эхний хагас жилд:**<br>Сумын нутаг | Аймгийн Засаг даргын Тамгын газартай Вектор мэп ХХК нь “Алтай, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шинээр боловсруулах болон тодотгон боловсруулах ажлыг зохион байгуулах | аа | | дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсан. | дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, хянуулан батлуулсан байна.<br>Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулж, төлөвлөгөө боловсруулах явцад хяналт тавьж, үе шат бүр дээр дүгнэлт гаргаж ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.<br>**Жилийн эцэст:**<br>Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах явцад хяналт тавьж, ГЗБГЗЗЕГ-аас гаргасан мэргэжлийн дүгнэлтийг үндэслэн засвар, өөрчлөлтийг гүйцэтгэгчээр хийлгэж, сумын ИТХ-аар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан байна. | Баян-Уул, Бигэр, Бугат, Дарив, Дэлгэр, Жаргалан, Есөнбулаг, Тайшир, Тонхил, Төгрөг, Халиун, Хөхморьт, Цээл, Шарга сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах” зөвлөх үйлчилгээний №ГААХААГ/20240103082 дугаартай гэрээг 2024 оны 04 сард байгуулан аймаг, сумын төсвөөс санхүүжүүлэн ажиллаж байна. Захиалагчийн хяналтыг үе шатны ажлуудад гүйцэтгэж байна. Вектор мэп ХХК нь 2024 оны 12 сард 3 сумын (Бигэр, Дарив, Есөнбулаг) төлөвлөгөөг, 2025 оны 03 сард 12 сумын төлөвлөгөөг сумдад хүлээлгэн өгнө. Ингэснээр Говь-Алтай аймгийн бүх сумд газар зохион байгуулалтын дунд хугацааны бодлогын баримт бичигтэй болно. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.9.**<br>**Мэдлэгт суурилсан, иргэд, олон нийтийн оролцоотой газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөлтийн системийг бий болгоно.** | | | | | | | |
| **1.9.1** | **Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг** | **Үйл ажиллаг аа** | **Аймаг бүрээр боловсруул** | **21 аймаг, 330 сумын хилийн цэсийг** | **Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **нийгэм, эдийн засаг, хүн амын өсөлт, байгалийн нөхцөл, нөөцийн чадавхид нийцүүлэн оновчтой зохион байгуулах, хуваарилах** | | **сан санал** | **тодотгосон.** | **боловсронгуй болгох саналыг боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.** | | |
| 1.9.1.1 | Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 24 дүгээр тушаалаар байгуулагдсан "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн маргааныг шийдвэрлэх талаар санал, дүгнэлтийг гаргах үүрэг бүхий Ажлын хэсэг"-ээс гаргасан дүгнэлтийн дагуу орон нутгийн удирдлагууд, иргэд, олон нийтэд хилийн цэсийн талаарх үнэн зөв мэдээллийг өгөх ажлыг зохион байгуулж, тайлан, мэдээг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх | Үйл ажиллагаа | Тайлан хүргүүлсэн байдал | Бүх сумдын хилийн цэсийг тодотгосон. | Орон нутгийн удирдлагууд, иргэд, олон нийтэд хилийн цэсийн талаарх үнэн зөв мэдээллийг өгөх ажлыг зохион байгуулж, тайланг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна | Багийн хилийн зааг, багийн нэр баталсан судалгааг сумдаас 2024 оны 04 сарын 01-ны өдрийн 156 дугаар албан бичгээр хүлээн авч нэгтгэн ГЗБГЗЗЕГ-н хилийн цэсийн асуудал хариуцсан мэргэжилтэн Тэргүүнцэцэгт хүргүүлсэн.<br>2024 онд аймгийн 15-н суманд Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө хийж байгаатай холбогдуулан нийт сумдын багийн хилийн заагийг сумын ИТХ-аар хэлэлцүүлэн аймгийн ИТХ-р батлуулахаар ажиллаж байна. 2023 онд гарсан Шарга сум, Тайшир сумын хилийн цэсийн эргэлтийн 2-цэг дээр очиж магадлан хэмжилтийг шүүхийн байгууллагатай хамтран хийж гүйцэтгэн маргааныг таслан зогсоосон.Мөн Бугат сум, Алтай сум, Цогт сум, Эрдэнэ сумдын хилийн цэсийн маргааныг 2 талаас ажлын хэсгийг ажиллуулан таслан зогсоосон. 2024 онд үүссэн хилийн цэсийн маргааны судалгаа нэгтгэн 2024 оны 11 сарын 04-ны өдрийн 585 албан бичгээр ГЗБГЗЗЕГазарт хүргүүлсэн. | **100** |

**Стратеги төлөвлөгөөний зорилго 1.13.**
**Төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх замаар салбарын хэмжээнд цахим шилжилт хийх үйл ажиллагааг дэмжих**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1.13.2** | **Салбарын үйл ажиллагаанд цахим гарын үсэг болон тоон гарын үсэг нэвтрүүлэх** | **Үйл ажиллагаа** | **85 тоон гарын үсэг** | **Салбарын хэмжээнд нийт 649 тоон гарын үсгийг шинэчлэн олгосон.** | **Газрын харилцааны салбарын нийт албан хаагчид тоон гарын үсэг ашигладаг болсон байна.** | | |
| 1.13.2.1 | Тоон гарын үсгийн олголт хийх, өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглах боломжийг нэвтрүүлэх | Үйл ажиллагаа | - Тоон гарын үсэг эзэмшигчийн тоо<br>- Тоон гарын үсгийг ашиглаж буй үйл ажиллагааны тоо | Салбарын хэмжээнд нийт 649 тоон гарын үсгийг шинэчлэн олгосон. | - Тоон гарын үсгийн олголтыг шинэчлэн хийсэн байна.<br>- Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд тоон гарын үсгийг ашигладаг болсон байна. | Тоон гарын үсгийг шинэчлэн шинээр тоон гарын үсэг авах албан хаагчдад олголт хийн бүртгэлжүүлж ажилласан. Мөн байгууллагын өдөр тутамын үйл ажиллагаанд тоон гарын үсгийг ашиглуулан ажиллаж байна. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.14.<br>Төрийн архивын стандарт орчныг сайжруулах** | | | | | | | |
| **1.14.1** | **Төрийн архивыг цахимжуулах, цахим мэдээллийн сан бүрдүүлэх, цахим үйлчилгээг нэвтрүүлэх** | **Үйл ажиллагаа** | **1764 хадгаламжийн нэгж** | **2022 онд Төрийн архивын 14879 хадгаламжийн нэгжийн баримтыг архивын цахим системд холбосон.** | **1764 хадгаламжийн нэгжийн баримтыг архивын цахим системд холбоно.** | | |
| 1.14.1.1 | Архивын баримтыг цахимжуулах, цахим мэдээллийн сан үүсгэх | Үйл ажиллагаа | Цахимжуулсан хадгаламжийн нэгжийн тоо | 2023 оны байдлаар 40 хадгаламжийн нэгжийн 7500 хуудас баримт цахимжсан. | **Эхний хагас жилд:**<br>25 хадгаламжийн нэгжийн баримтыг цахимжуулан Архивын цахим системд холбон, байнгын үйл ажиллагааг хангахад ГЗБГЗЗЕГ-ын Салбарын архивын хэлтэстэй хамтран ажиллаж холбогдох | 2024 оны жилийн эцсийн байдлаар 2023 оны 89 хадгаламжийн нэгжийн 9853 хуудас баримт, 2024 оны 11 хадгаламжийн нэгжийн 3210 хуудас баримтыг цахимжуулан Архивын цахим систем https://archive2.gazar.gov.mn/404/-д холбосон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | заавварчилгаа авсан байна.<br>**Жилийн эцэст:**<br>50 хадгаламжийн нэгжийн баримтыг цахимжуулан Архивын цахим системд холбон, байнгын үйл ажиллагааг хангахад ГЗБГЗЗЕГ-ын Салбарын архивын хэлтэстэй хамтран ажиллаж холбогдох заавварчилгаа авсан байна. | | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.15.<br>Төрийн болон албаны нууцыг хадгалж хамгаалах** | | | | | | | |
| **1.15.1** | **Төрийн болон албаны нууцыг хадгалж хамгаалах, хяналт тавих** | **Үйл ажиллагаа** | **Зохион байгуулсан ажлын тоо** | **-** | **Төрийн болон албаны нууцыг хадгалж, хамгаалах талаарх ажлуудыг зохион байгуулсан байна.** | | |
| 1.15.1.1 | Төрийн болон албаны нууцыг хадгалж, хамгаалах, хяналт тавих, Нууц албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлэх | Үйл ажиллагаа | 1 мэдээ,<br>1 тооллого | 2023 онд Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр явуулсан үйл ажиллагааны мэдээг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.<br>2023 онд Төрийн болон албаны нууцын тооллого хийж, дүн мэдээг хугацаанд нь | Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр 2024 онд хэрэгжүүлсэн ажлын мэдээг 2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор ТЕГ-ын орон нутаг дахь Тагнуулын газар, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.<br><br>Нууцын албан хэрэг хөтлөлтийн үйл | Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын мэдээ тайланг нэгтгэн Тагнуулын Ерөнхий газрын харьяа Говь-алтай аймаг дахь салбарт хүргүүлсэн. Мөн Аймгийн Тагнуулын хэлтсийн баталсан удирдамжийн дагуу 2024 оны 05 сарын 15-ны өдөр тус газраас төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалт, ашиглалтад төлөвлөгөөт хяналт шалгалт хийж ажилласан. Уг шалгалтаар ноцтой зөрчил | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | явуулсан. | ажиллагааг зохион байгуулж, нууц баримттай танилцах иргэний итгэмжлэлийг шинэчлэх, нууцын баталгаа авах, нотлох лавлагаа гаргаж өгөх, гадаад улсад зорчих эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтний урьдчилсан мэдүүлгийг авах, шилжилт хөдөлгөөний мэдээллийг тус тус бүртгэлжүүлж, мэдээ тайланг ТЕГ-ын орон нутаг дахь Тагнуулын газар, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. Аймгийн ГХБХБГ-ын төрийн болон албаны нууцын хадгалалт хамгаалалтын үзлэг тооллого хийсэн байна. Тооллогын мэдээг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | илрээгүй болно. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.20.** **Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн суурь өгөгдлийг бүрдүүлэх, мэдээллийн нэгдсэн системийг бүрэн ашиглалтанд оруулж, хэрэглээнд нэвтрүүлнэ.** | | | | | | | |
| **1.20.1** | **Инженерийн дэд бүтэцтэй холбоотой мэдээллийг Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд** | **Үйл ажиллагаа** | **Инженерийн дэд бүтцийн мэдээлэл** | **-** | **Төлөвлөлтийн инженерийн дэд бүтэц, бэлтгэл ажлын мэдээллийг хот байгуулалтын кадастрын цахим** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **бүртгэх** | | | | **системд бүртгэсэн байна.** | | |
| 1.20.1.1 | Инженерийн дэд бүтэц, инженерийн бэлтгэл арга хэмжээний орон зайн тоон зургийг холбогдох хангагч, ашиглалт хариуцсан байгууллагатай хамтран баяжилт хийх, мэдээллийг Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Төлөвлөлтийн 7 давхаргын мэдээлэл | - | Аймгийн хэмжээнд Хот байгуулалтын кадастрын системд төлөвлөлтийн 7 давхаргын мэдээллийг бүртгэсэн байна. | Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан 2024 оны 05 сарын 01-ны өдрөөс үйл ажиллагаанд хэвийн орсон.<br>2024 оны жилийн эцсийн байдлаар 3 төрийн байгууллага, 1 аж ахуй нэгж, 5 иргэний барилгын тэг тэнхлэгийн актын мэдээлэл, барилгын инженерийн шугам сүлжээний мэдээлэлийг хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэсэн болно.<br>Нөхөн бүрдүүлэлтээр Чандмань сум, Төгрөг сум, Хөхморьт сум, Цогт сум, Бугат сум, Тонхил сум, Баян-Уул сум, Бигэр сум, Дэлгэр сум, Шарга сум, Жаргалан сумдын дулаан шугам болон ариутгах татуургын инженерийн шугам сүлжээний мэдээлэл, трассыг оруулан ажилласан. Мөн 15-н сумдыг холбосон холбооны шилэн кабелийн трасс, инженерийн шугам сүлжээний мэдээллийг хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүрэн оруулж дууссан.<br>Уг инженерийн шугам сүлжээний мэдээллийн гүйцэтгэлийн зураглалыг Геодези зураг зүйн тусгай зөвшөөрөлтэй “Эс жи повер” ХХК-иар хийж гүйцэтгүүлэн хяналтыг тухай бүр нь хийж гүйцэтгэн ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1.20.2** | **Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг танилцуулах, сурталчилах** | **Үйл ажиллагаа** | **2 арга хэмжээг авч хэрэгжүүлэх** | **-** | **Хот байгуулалтын кадастрын мэдээллийн нэгдсэн системийг сурталчилсан байна.** | | |
| 1.20.2.1 | Хот байгуулалтын кадастрын цахим системийг олон нийтэд сурталчилах | Үйл ажиллагаа | 4 арга хэмжээ | - | **Эхний хагас жилд:**. Хот байгуулалтын кадастрын цахим системийг олон нийтэд сурталчлах чиглэлээр 2 арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлсэн байна. **Жилийн эцэст:** Хот байгуулалтын кадастрын цахим системийг олон нийтэд сурталчлах чиглэлээр 2 арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлсэн байна. | Хуульчдын про боно нээлттэй хаалганы өдөрлөгийг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулагдаж тус нээлтэй хаалганы өдөрлөгөөр хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж, тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа барилгын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж байгууллагад 2024 оны 05 дугаар сард хөдөлмөр хамгаалын чиглэлээр сургалт явуулж сургалтын үеэр хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг хэрхэн ашиглах талаар мэдээлэл зөвлөмж өгч ажилласан. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.21.<br>Хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлнэ.** | | | | | | | |
| **1.21.1** | **Аймгийн хэмжээнд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдад хяналт шалгалт хийх** | **Үйл ажиллагаа** | **Хэрэгжилтийн хувь** | **-** | **Газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон газрын төлөв байдал, чанарын хянан магадлагааны хэрэгжилтийг 80%-д хүргэсэн байна.** | | |
| 1.21.1.1 | Аймгийн хэмжээнд газар, геодези, зураг | Үйл ажиллаг | Шалгалт хийсэн | - Их, дунд эрсдэлтэй | Шалгалтаар их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн | Тус газраас 10 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад төлөвлөгөөт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зүйн чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 10 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх | аа | объектын тоо, гүйцэтгэлийн хувь, хууль сахин мөрдөлтийн түвшин, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь | үнэлэгдсэн 576 объектод төлөвлөгөөт шалгалт хийхээр "Хяналт шалгалтын төлөвлөгөөг" Засгийн газрын 2023 оны 79 дүгээр тогтоолоор батлуулсан.<br>- Барилга, хот байгуулалтын Сайдын 2023 оны 74 дүгээр тушаалаар батлуулсан. | нийт объектын эрсдэлийн түвшинг бууруулсан байна.<br>Хяналтын хуудсаар илэрсэн зөрчлийг арилгуулсан байна.<br>Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс 7 объектод хяналт шалгалт хийж төлөвлөгөөний биелэлт 100%-тай байна. /3 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа зогссон/<br>Шалгалтыг 7 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хийхэд 5 нь дунд, 2 нь их эрсдэлтэй үнэлэгдэж, нийт 40 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 6 албан шаардлага хүргүүлэн 20.5 сая төгрөгийн торгууль ногдуулан ажиллав.<br>Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 4 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хийж гүйцэтгэсний үр дүнд эрсдэл 11.2%-аар буурч хуулийн хэрэгжилт 8.3%-аар өссөн байна.<br>Төлөвлөгөөт хяналт шалгалтын танилцуулгыг ГЗБГЗЗЕГ-т 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 610 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | |
| 1.21.1.2 | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн "Газрын кадастрын цахим систем"-д нэгж талбарын цахим хувийн хэргийн бүрдүүлэлтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх. | Үйл ажиллагаа | Хяналт шалгалтад хамрагдсан объектын тоо, гүйцэтгэлийн хувь, хууль сахин мөрдөлтийн түвшин, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн "Газрын кадастрын цахим систем"-д нэгж талбарын цахим хувийн хэргийн бүрдүүлэлтэд хяналт хийх, дүгнэлт гаргах, авах арга | Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна.<br>Шалгалтын дүнг хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна.<br>Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн | Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 35-00/08 дугаартай удирдамжийн хүрээнд Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд нэгж талбарын цахим хувийн хэргийн бүрдүүлэлтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 18 сумын 1120 хувийн хэргийг сонгон авч хувийн хэргийн баримт материал, мэдээллийг холбогдох журмын дагуу оруулсан байдлыг шалгахад 865 хувийн хэргийн баримт материалын бүрдэл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт | хэмжээний саналыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, удирдамжийн дагуу цахим системд үүсгэсэн хувийн хэргийн 1.2 хувь буюу 13,501 нэгж талбарын хувийн бүрдүүлэлтэд хяналт хийсэн. | биелэлтийг бүрэн хангуулсан байна. | хангаагүй зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 14 албан шаардлага хүргүүлж, биелэлт 87%-тай байна.<br>Хяналт шалгалтын танилцуулгыг 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 580 дугаартай албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. | |
| 1.21.1.3 | Тусгай зөвшөөрөлтэй болон мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Үйл ажиллагаа | Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, эрсдэлийн түвшин буурсан объектын тоо | - | Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна.<br>Дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна.<br>Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 35-00/12 дугаартай удирдамжийн хүрээнд Говь-Алтай аймгийн хэмжээнд геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг “Эс жи повер” ХХК-ний үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 35.5 кодтой “Геодези, зураг зүйн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-аар хийхэд 36%-аар дунд эрсдэлтэй үнэлэгдэж, 5 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж ажилласан.<br>Хяналт шалгалтын танилцуулгыг 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 581 дугаар албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. | 100% |
| 1.21.1.4 | Соёл, урлагийн байгууллагын газар | Үйл ажиллаг | Шалгалт хийсэн | - | Батлагдсан удирдамжийн хүрээнд | Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 35-00/06 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эзэмшил, ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | аа | объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, эрсдэлийн түвшин буурсан объектын тоо | | хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна.<br>Дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлж, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна.<br>Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | дугаартай удирдамжийн хүрээнд Говь-Алтай аймгийн хэмжээнд соёл, урлагийн байгууллагын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 18 сум, 2 тосгоны 21 байгууллагын газар эзэмшил, ашиглалт болон Улсын хамгаалалтад байх соёлын үл хөдлөх 11 дурсгалт газруудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж 45 зөрчил илрүүлэн, 16 зөрчлийг газар дээр нь арилгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах зорилгоор 5 албан шаардлага хүргүүлж, биелэлт 90%-тай байна.<br>Хяналт шалгалтын танилцуулгыг 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 551 дугаартай албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. | |
